



**БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 07 сарын 29-ны өдөр

Дугаар 38

Булган сум

Ээлжит хуралдаан зарлан
хуралдуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сумын ИТХ-ын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит V хуралдааныг 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 10 цагт Булган сумын Соёлын ордонд хуралдуулсугай.
2. Хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын мэдээлэл, холбогдох тооцоо судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг чанартай бэлтгэх, хуралдах байр, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах болон бусад зохион байгуулалтын арга хэмжээг бүрэн хангаж ажиллахыг сумын Засаг дарга П.Нөхөрлөлбаярт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хурлын Нарийн бичгийн дарга Д.Нарангэрэлд даалгасугай.

ДАРГА



Б.ГАНЗОРИГ